1. MNS-ISO 5457-0:2003 стандартаар тогтоосон А4 дэвсгэртийн хэмжээг сонгоно уу.
   A. 420x594 B. 297x420 C. 210x297 D. 148x210

2. Изометрийн тэнхлэгийг 30, 60, 90 градусын өнцөгтэй гурвалжин шугам ашиглан байгуулах аргыг харуулсан зургийг сонгоно уу.




A.




B.




C.




D.

3. Биетийн гурван талыг (урт, өргөн, өндөр) нэг дүрслэлээр харуулж хэлбэр, хэмжээг нь ойлгомжтой дүрсэлдэг проекцлолын аргыг сонгоно уу.
   A. тэгш өнцгийн проекц B. аксонометр проекц
   C. хэвтээ ба босоо проекц D. төвийн ба параллел

4. Зурагт үзүүлсэн биетийн тэгш өнцгийн проекцыг зөв дүрсэлсэн хариуг сонгоно уу.





A.



B.



C.



D.

5. Ажлын зураг зурахын өмнө зургийн дэвсгэрт дээр эхлээд хүрээ шугам татах, үндсэн бичээс хийх хүснэгттээ зурж бэлтгэдэг. Хүрээ шугамыг зөв хэмжээгээр зурсан зургийг сонгоно уу.




A.




B.




C.




D.

6. Изометр проекцын аргаар дүрсэлсэн биетийг сонгоно уу.




A.




B.




C.




D.

7. Зурагт үзүүлсэн деталийн тэгш өнцгийн проекцыг зөв дүрсэлсэн хариуг сонгоно уу.




A.


B.


C.


D.

8. Зурагт үзүүлсэн “Pop corn”-ны хайрцгийг диметр проекцын тэнхлэг дээр зөв байгуулсан хариуг сонгоно уу.





A.


B.


C.


D.

9. Зурагт үзүүлсэн биетүүдийг тэгш өнцгийн проекцтой зөв харгалзуулсан хариуг сонгоно уу.


**1.**


**2.**


**3.**


**a.**


**b.**


**c.**

A. 1-a, 2-c, 3-b　　B. 1-a, 2-b, 3-c　　C. 1-c, 2-b, 3-a　　D. 1-b, 2-a, 3-c

10. Оёдлын машины эд хөөгч улны үндсэн үүргийг сонгоно уу.
   A. дээд утсыг хөөж дамжуулах
   B. материалыг дарах
   C. материалыг жигд урагш хөдөлгөх
   D. улны утсыг тохируулах

11. Зурагт үзүүлсэн оёдлын цахилгаан машины оёдлуудыг нэртэй нь зөв харгалзуулсан хариуг сонгоно уу.



1. 2. 3.

**a.** хавсрах оёдол **b.** ирмэг битүү нугалах оёдол **c.** ирмэг задгай байхаар нугалж оёх

A. 1-a, 2-b, 3-c B. 1-b, 2-c, 3-a C. 1-c, 2-a, 3-b D. 1-b, 2-a, 3-c

12. Юбканы эсгүүр байгуулахад биеэс авах хэмжээсүүдийг зөв нэрлэсэн хариуг сонгоно уу.




A. 1-өгзөгний тойрог, 2-бэлхүүсний тойрог, 3-юбканы урт, 4-суудлын өндөр
B. 1-суудлын өндөр, 2-өгзөгний тойрог, 3-юбканы урт, 4-бэлхүүсний тойрог
C. 1-юбканы урт, 2-өгзөгний тойрог, 3-бэлхүүсний тойрог, 4-суудлын өндөр
D. 1-бэлхүүсний тойрог, 2-өгзөгний тойрог, 3-юбканы урт, 4-суудлын өндөр

13. Өвдөгөөр татсан урттай юбкыг ямар юбка гэж нэрлэдэг вэ?
A. микро B. мини C. миди D. макси

14. Шулуун юбканы торны өргөнийг олох томьёог сонгоно уу.
A. бэлхүүсний тойрог/4 B. өгзөгний тойрог/2
C. (өгзөгний тойрог/2)+5 D. цээжний тойрог/4-1

15. Юбкануудыг эсгүүрийн загварчилгаатай нь зөв харгалзуулсан хариуг сонгоно уу.



**1.**



**2.**



**3.**




**a.**




**b.**




**c.**

A. 1-a, 2-b, 3-c　　B. 1-b, 2-c, 3-a　　C. 1-b, 2-a, 3-c　　D. 1-c, 2-a, 3-b

16. Бүтэн наран юбканы эсгүүрийг нарийн энтэй материал дээр байрлуулсан зургийг сонгоно уу.



A.



B.



C.



D.

17. Зурагт өгөгдсөн шулуун юбканы торын **Б-Х** эсгүүрийн шугамыг зөв нэрлэсэн хариуг сонгоно уу.




A. арын голын шугам
B. урд талын голын шугам
C. хажуу оёдлын шугам
D. бэлхүүсний шугам

18. Нэхмэл материалын шинж чанарыг тодорхойлох туршилтуудыг нэртэй нь зөв харгалзуулсан хариуг сонгоно уу.

| | |
|---|---|
| **1.** Үрчийлт | **a.** Үндсэн ба сууръ утасны чиглэлд болон $45^0$ -ын налуугийн дагуу татаж харьцуулах. |
| **2.** Суналт | **b.** Даавууг хайчилж утасны сэмрэлтийг ажиглах. |
| **3.** Сэмрэлт | **c.** Даавууг базаж үзээд хэрхэн тэнийж буй байдлыг ажиглаад харьцуулах. |

A. 1-a, 2-c, 3-b B. 1-b, 2-a, 3-c C. 1-c, 2-a, 3-b D. 1-a, 2-b, 3-c

19. Зурагт өгөгдсөн шулуун юбкыг оёх технологи дараалльг гүйцээх зөв хариуг сонгоно уу.



| |
|---|
| 1. ..................................... |
| 2. Юбканы хажууг нийлүүлж оёх. |
| 3. .................................... |
| 4. .................................... |
| 5. Хормойг оёх. |

A. 1-бүс оёх, 3-танаас оёх, 4-далд цахилгаан оёх
B. 1-танаас оёх, 3-бүс оёх, 4-далд цахилгаан оёх
C. 1-танаас оёх, 3- далд цахилгаан оёх, 4-бүс оёх
D. 1-далд цахилгаан оёх, 3-бүс оёх, 4-танаас оёх

20. Хос зүүгээр сүлжих дарааллын өнгөн гогцооны тэмдэглэгээг сонгоно уу.



A. B. C. D.

21. Хэрэглэхгүй болсон сүлжмэл эдлэлийн утсыг дахин ашиглахад бэлтгэх үе шатуудыг зөв дараалалд оруулсан хариуг сонгоно уу.

    a. Утсыг хөвж сандлын хөлд ороono.
    b. Эхлээд уг сүлжмэл эдлэлээ угааж цэвэрлэнэ.
    c. Утсаа гэмтээлгүйгээр бөөрөнхийлөн ороож авна.
    d. Утсыг чийглэн тэгшилж хатаана.

A. a, b, c, d B. b, a, d, c C. b, c, d, a D. a, b, d, c

22. Хос зүүний энгийн сүлжээсийг сонгоно уу.


A.

B.

C.

D.

23. Зурагт үзүүлсэн эдлэлүүдээс хос зүүгээр сүлжээгүй эдлэлийн зургийг сонгоно уу.


A.

B.

C.

D.

24. Хүндэтгэлийн ширээн дээр байрлуулсан хутга, сэрээ, халбага зэрэг хэрэгслийг хэрхэн хэрэглэдэг вэ? Зөв хариуг сонгоно уу.




A. Дуртайгаа эхэлж хэрэглэнэ.
B. Хоолондоо тааруулж хэрэглэнэ.
C. Тавгийн дэргэд хамгийн ойр байгаагаас нь эхэлж хэрэглэнэ.
D. Тавгийн 2 талд хамгийн захад байгаас нь эхэлж хэрэглэнэ.

25. Бат айлд уригдаж гэр бүлийн гишүүдтэй оройн хоол хамт иджээ. Бат хамгийн эхэнд хооллож дуусаад хутга сэрээг зэрэгцүүлэн таваг дээр дээш харуулан тавиад ширээнээс босжээ. Бат хооллох соёлд гаргасан буруу үйлдлийг сонгоно уу.
    A. Бусад хүмүүс хооллож дуусаагүй байхад ширээнээс боссон.
    B. Хутга, сэрээг зэрэгцүүлэн таваг дээр дээш харуулан тавьсан.
    C. Өөрийн хоолоо идэж дууссан тул босох шалтгаанаа зөвтгөсөн.
    D. Хоол идэж байхдаа хутга, сэрээг нэг гараас нөгөөд шилжүүлэн хэрэглэсэн.